



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/661

Булган сум

Г Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл 32.1.1, Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.18, 12 дугаар зүйлийн 12.1.2 дах заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 87 дугаар тушаалаар батлагдсан "АВТО ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЖИШИГ ҮНЭ ТООЦОХ АРГАЧЛАЛ", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" ХХV/05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтын 2.2 дахь заалт, Булган аймгийн Онцгой комиссын 2024 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган сумын 4 дүгээр багт 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр 17:20 минутад орсон түр зуурын хүчтэй аадар борооны улмаас Зүүн түрүүний гол үерлэж төмөр бетон гүүр нурж, Авто замын Улсын хяналтын байцаагчийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 04-17-02/131/01 тоот дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй болсон тул эргийн бэхэлгээ, төмөр бетон гүүрний ажлын зураг төслийг яаралтай боловсруулж 2025 оны Улс, орон нутгийн төсөв тусгагдах зайлшгүй шаардлага үүссэн тул анхны ажлын зураг төсөл зохиогч "Тарвачинбүүлэн" ХХК-тай 80,000,000 (наян сая) төгрөгөөр шууд гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Тарвачинбүүлэн" ХХК-ийн захирал (А.Жигжидсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д тус тус даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр тухай бүр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ